

**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХЭЛТСЭЭС 2017-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН
ТОВЧ ТАЙЛАН**

АГУУЛГА

1. Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр
2. Хүний нөөцийн программ хангамжийн шинэчлэл
3. Төрийн албан хаагчийн цаасан болон цахим хувийн хэргийн шинэчлэл

**1.Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр
(2017-2020 он)**

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 07-р сарын 04-ний өдрийн А/164 дүгээр тушаалаар “Гаалийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”, “Гаалийн байгууллагын ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны дэд хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлсэн.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн зорилго
Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн эрх зүйн орчин
Хөтөлбөрийн зарчим, хэрэгцээ шаардлага
Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа
Хөтөлбөрийн зорилт
Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт
Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт
Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

агуулгаас бүрдсэн.

“Гаалийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”, “Гаалийн байгууллагын ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны дэд хөтөлбөр”-үүдийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

Тайлант хугацаанд Гаалийн байгууллагын ажилтан албан хаагчдыг сувилалд хамруулах зардал 79 сая 704 мянган төгрөгийг батлуулж, Шаргалжуут, Баатарван, Хужирт рашаан сувиллын газруудад гаалийн байгууллагын 647 ажилтан, албан хаагчдыг, ахмад гаальчдаас “Тарни” амралтад 30 албан хаагчийг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулсны үр дүнд ГЕГ, ДоГГ, ГСГГ, ШХГГ, УХШИГГ-ын албан хаагчид буюу нийт 576 ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Мөн 2020 онд КОВИД-19 цар тахлын өвчлөл нэмэгдсэнтэй холбогдуулан 1785 албан хаагчид PCR шинжилгээ хийлгэх ажлыг бусад газар, хэлтэстэй хамтарч зохион байгуулав. Харьяа гаалийн газар, хорооны дарга нарт жил бүр албан хаагчдаа тогтмол эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж байх талаар 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 01-5/3693 дугаартай албан тоотоор мэдэгдсэн. Гаалийн байгууллагын ажилтнуудын дунд биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулахаар

төлөвлөж, “Эрүүл мэнд аялал”-ын арга хэмжээг Төв аймгийн Манзушир хийдээс Богд хайрхан уулын ноён оргил Цэцээ гүний чиглэлд ГЕГ-ын ЗББН, ДБ-ын хамт олны дунд 3 удаа амжилттай зохион байгуулж 190 гаруй ажилтан хамрагдсан.

Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын дагуу 102 албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарах хүсэлтийг шийдвэрлэж 2.2 тэрбум төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, гаалийн байгууллагад ажиллаж байгаад нас барсан 12 албан хаагчийн ар гэрт 121 сая төгрөгний буцалтгүй тусламж, ар гэрийн гачигдал тохиолдсон 147 албан хаагчид 45,4 сая төгрөгний тусламж, 55 албан хаагчийн эрүүл мэндийн шалтгааныг судлан эмчилгээний зардалд нийт 118.9 сая төгрөгний буцалтгүй тусламжийг тус тус олгуулсан.

2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 01-5/3693 дугаартай албан бичгээр “Хилийн боомтод ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчдын гэр бүлийн ажил эрхлэлтийн судалгаа хийж, ажил эрхэлдэггүй 116 гэр бүлийн гишүүнд Гаалийн тухай хуулийн 282.7 дахь заалтыг үндэслэн гэр бүлийн гишүүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож олгох, нийгмийн даатгалын хэлтэст төлөх талаар санхүүгийн асуудал хариуцсан чиг үүргийн нэгжид санал хүргүүлсэн.

2017-2020 онд Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдлийг 7 удаа шинэчлэн тогтоосон.

"Гаалийн байгууллагын ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон сууцны нөхцөл, эрэлтийн талаар нарийвчилсан судалгаа хийж, мэдээллийн сантай болох ажлын хүрээнд судалгааны маягт боловсруулж, Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын нийт гаалийн улсын байцаагч, албан хаагчдыг хамруулж, судалгааг нэгтгэн ажиллагчдын амьдрах байр, арилжааны банкинд зээлтэй эсэх талаарх нэгдсэн судалгаатай болсон. Засгийн газраас хэрэгжүүлсэн Төрийн албан хаагчдыг “Түрээслээд өмчлөх орон сууц” төсөлд 21 албан хаагчийг хамруулах ажлыг зохион байгуулж, 21 төрийн албан хаагч өөрийн орон сууцтай болсон.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр:

Гаалийн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын төсөл,
Засгийн газрын 1997 оны 153 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан гаалийн улсын байцаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөл,
Тус тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан “гаалийн улсын байцаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөл,
Гаалийн тухай хуулийн шинэчлэн найруулсан төслийн Гаалийн улсын байцаагчийн эрх зүйн байдлын тухай дэд бүлэг,
Гаалийн байгууллагын бүтцийн нэгж, харьяа газруудын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлд адилтгасан санал,
Гаалийн байгууллагын бүтэц, орон тооны төсөл

“Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Монгол улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад дурьдагдсан “ Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”-ийн дагуу нийт Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх газар, харьяа гаалийн газар хороодын төрийн үйлчилгээний нийт 26 албан тушаалын зэрэглэлийг тулган шалгасан. Үүнд: Малын эмч ТҮ-5-р зэрэглэлээс ТҮ-7-р зэрэглэлд, Хүргэлт, лавлагаа гаргах ажилтан ТҮ-4-р зэрэглэлээс ТҮ-2-р зэрэглэлд, Мэргэжилтэн ТҮ-7-р зэрэглэлээс ТҮ-6-р зэрэглэлд хамруулж шинэчлэн тогтоов. Цалингийн зөрүүг Санхүүгийн асуудал хариуцсан холбогдох нэгжтэй хамтран тооцож судалгааг гаргасан.

Дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд өндөр насны тэтгэвэрт гарах , хүүхэд асрах чөлөө олгох, хүүхэд асрах чөлөөний хугацаа нь дуусч ажилдаа эргэн орох хүсэлт гаргасан албан хаагчийн, төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдыг түрээсийн орон сууцны, арилжааны банкинд зээлтэй албан хаагчийн, 2016 оноос хойш нас барсан төрийн албан хаагчийн ар гэрт олгосон тэтгэмжийн , нас хүйсийн, өвчлөлийн, 50-аас дээш насны албан хаагчдын, 0-12 насны хүүхэдтэй албан хаагчдын, төрийн албан хаагчдын оршин суугаа хаягийн , ажилчдын ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа болон бусад судалгааг тухай бүр хийж үр дүнд холбогдох арга хэмжээг байнга авч ажиллаж байна.

2. Хүний нөөцийн программ хангамжийн шинэчлэл

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/102 дугаар тушаалаар "Хүний нөөцийн программ хангамж"-ийг шинэчлэн боловсруулж, нэвтрүүлэх ажлын хэсгийг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төвтэй хамтран байгуулсан бөгөөд үүний үр дүнд Захиргаа дотоод ажлын системийн программд Хүний нөөцийн нэгдсэн дэд программыг хөгжүүлж, ашиглалтад оруулсан.

Энэхүү программ нь Төрийн албан хаагчийн анкетийг цахим байдлаар гаалийн системийн хэмжээнд бүрэн оруулах боломжийг бүрдүүлсэн. Програмаас бүх төрлийн судалгааг гаргах боломжтойгоор шийдлийг хийж програмчлалын боловсруулалт хийгдсэн бөгөөд хүний нөөцийн талаар цаг тухай бүр шийдвэр гаргахад Хүний нөөцийн програмаас шаардлагатай мэдээллийг гарган удирдлагыг шуурхай, үнэн бодит мэдээлэллээр ханган ажиллах боломж бүрдсэн юм.

Хүний нөөцийн программ ашиглан судалгааг гаргаж Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Сангийн яамнаас ирсэн хяналт, шалгалтын ажлын хэсгүүдэд танилцуулж ажилласан ба ажлын хэсгүүдээс тухай бүр өгсөн зөвлөмж, зөвлөгөөг програм болон бусад судалгаандаа тусгаж ажлын үр дүнг дээшлүүлэхэд зөвлөмжийн үр нөлөөг ашиглаж ажилласан.

3.Төрийн албан хаагчийн цаасан болон цахим хувийн хэргийн шинэчлэл

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан 2019 оны 6 дугаар сараас эхлэн гаалийн байгууллагын системийн хэмжээнд нийт ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн авч хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, баяжилтийг хийх зорилгоор хуучин хувийн хэргийг нь шинээр бүрдүүлж

өгсөн хувийн хэрэгтэй нь нэгтгэж бүх мэдээллийг тулган шалгаж, шинээр хавтаслан албан хаагчдын хувийн хэргийн мэдээллийг баяжуулж, хадгалалт хамгаалалтыг сайжруулан Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллав.

ДҮГНЭЛТ

ГЕГ-ын ХШҮДАХ-ээс Гаалийн байгууллагын 2017-2020 оны Хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн байдлаар “ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ” гэж дүгнэж 2 санал, зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнд цаашид хүний нөөцийн хөтөлбөр боловсруулахдаа тоо болон чанарын үзүүлэлтийг тусгаж төлөвлөх, албан хаагчийн ур чадвар, мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, төрөл бүрийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудыг ГЕГ-ын ХМССТ, Удирдлагын Академи зэрэг бусад сургалт, судалгааны байгууллагуудтай хамтран зохион байгуулж байхыг зөвлөсөн.

Гаалийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, Гаалийн байгууллагын албан хаагчдын сургалт, хөгжил гэсэн 3 чиглэлээр судалгаа хийж Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийг 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн хамт боловсруулсан.

Уг төслийг 2022 оны 1 дүгээр улиралд ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Хөтөлбөр батлагдсанаар Төрийн албаны чадахуйн зарчим болон Төрийн албаны хуульд заасан албан хаагчдын нийтлэг болон нэмэгдэл баталгаа хангагдах, албан хаагчийн хувьд мэргэшлийн ур чадвараа дээшлүүлэх, хувь хүний хувьд хөгжих, байгууллагын соёлын түвшин сайжрах боломж бүрдэнэ.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС